

# СОЁМБОМЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН 2021.07.02 №87 (87)

## БАТЛАН ХАМГААЛАХЫН ДЭД САЙД Б.БАЯРМАГНАЙ БНЧУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙДТАЙ УУЛЗЛАА



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ийржи Бродскийг хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар хоёр улсын болон тэр тусмаа батлан хамгаалах салбарын өнөөгийн харилцаа, цаашид өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцов.

Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай Элчин сайд Ийржи Бродскийг хүлээн авч уулзаж буйдаа баяртай байгаа илэрхийлээд хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаанд түүний оруулж буй хувь нэмэр их гэдгийг онцолж, Зэвсэгт хүчний

үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх, зэвсэг техникийг шинэчлэхэд тус улсын дэвшилтэт технологийг судлах, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн салбарт хамтран ажиллах нь чухал ач холбогдолтойг онцлолоо.

Тэрчлэн Элчин сайд Ийржи Бродский түүний хүсэлтийг хүлээн авч уулзаж байгаадаа талархлаа илэрхийлээд цаашид хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа, түүний дотор Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны өнөөгийн түвшинг ахиулж, хоёр улсын Батлан хамгаалах яамд хооронд байгуулсан "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн хэрэгжилтийг хангах чиглэлд анхаарал хандуулж ажиллахаа илэрхийлсэн юм.

## ЦЭРГИЙН ХОЛБОО ҮҮССЭНИЙ ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН ХУРАЛ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ...



Цэргийн холбоо үүсэж хөгжсөний 100 жилийн түүхэн ой энэ өдрүүдэд тохиож байна. Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, Ардын хувьсгалын 100, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 110, орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жил зэрэг түүхт ойтой давхцаж байгаагаараа ихээхэн онцлогтой юм. Эл ойд зориулсан баярын хурал өчигдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдав.

Хуралд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа

Ж.Болдбаатар, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар, ЗХЖШ-ын Холбоо, мэдээллийн технологийн хэлтсийн дарга, хурандаа М.Золзаяа ахмад холбоочид, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын холбоочид оролцлоо.

Хурлыг ЗХЖШ-ын Холбоо, мэдээллийн технологийн хэлтсийн дарга, хурандаа М.Золзаяа "Цэргийн холбоочдын 100 жилийн дайчин уламжлал, өнөө ба ирээдүй" илтгэлээр эхлүүлсэн бол үргэлжлүүлээд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан

хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг нарын мэндчилгээг уншиж танилцуулсан юм.

Мөн тус баярын хурлын үеэр "Богино долгионы 1квт-ын "Монрадио-1000" радио станцыг танилцуулав. Энэхүү радио станцыг Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн холбоочид, инженерүүд зохион бүтээсэн ба орчин үеийн стандартад нийцсэн оператив-тактикийн түвшний радио станцууд аж. Цаашид ийм богино долгионы станцуудыг дотооддоо зохион бүтээж, үйлдвэрлэх улмаар эдийн засгийн чадамжид тулгуурлан дунд хүчний радио станцуудыг үе шаттайгаар солих зорилтыг дэвшүүлсэн аж.

Дээрх зорилт бодит ажил болсноор одоо ашиглагдаж байгаа богино долгионы радио станцуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, тэдгээрийн холбоо хангах холын зайг уртасгах, овор хэмжээг багасгах, эрчим хүчний зарцуулалтыг хоёр дахин бууруулах, сүүлийн үеийн олдоцтой элемент / LDMOS болон программчлагддаг микро контроллер/-үүдэд тулгуурлаж хийх, ашиглахад хялбар хийцтэй, автомат болон гар ажиллагаатай болгох, давтамжийн царааг 10 хувааж, контроллероор удирдах зэрэг олон давуу талтай юм байна.



ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
өдөр	шөнө
17	6
ӨМӨНД СУДАН	
өдөр	шөнө
32	23

ВАЛЮТЫН ХАНШ		
Валют	Авах	Зарах
USD	2.851.00	2.853.00
EUR	3.375.00	3.95.00
CNY	441.00	442.00
RUB	38.40	40.10
JPY	25.36	25.84
KRW	2.43	2.57

### ЗУРХАЙ

#### АРГЫН ТООЛЛЫН 2021 ОНЫ ДОЛДУГААР САРЫН 2, БААСАН ГАРАГ

**ЗУНЫ ДУНД ХӨХ МОРЬ САР ТАВАН ШАР ЦАГААЧИН ГАХАЙ ӨДӨР**

**НАРАН УРГАХ ШИНГЭХ: 04:57-20:55**

**ҮС ЗАСУУЛБАЛ: Эд эдлэл ундаа идээ олдono**

**БАРИЛДЛАГА: идэр**

**ШҮТЭН БАРИЛДЛАГА: Төрөхүй**

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. Муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр, эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой.



### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН  
117.963

ЭДГЭРСЭН  
78.434

НАС БАРСАН  
578/15

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
3440 (59)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ  
339

ЭДГЭРСЭН  
3040

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол  
Нийт: 182,204,857

Эдгэрсэн  
Нийт:

Нас барсан  
Нийт: 3,967,035



## ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.ГҮРРАГЧААГИЙН ХУВИЙН ХӨМРӨГИЙГ ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ ХҮЛЭЭН АВЛАА

Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойн хүрээнд Монгол Улс, ЗХУ-ын баатар, сансрын нисэгч, хошууч генерал Ж.Гүррагчаагийн амьдрал, үйл ажиллагааныхаа явцад буюу 1960-2021 оны хооронд бий болгосон цаасан суурьтай баримт

нисэгч, хошууч генерал Ж.Гүррагчаа, Архивын ерөнхий газрын дэд дарга Ч.Оюунчимэг, Одон орон геофизикийн хүрээлэнгийн захирал, академич С.Дэмбэрэл, Үндэсний төв архивын захирал Т.Сайнжаргал болон албаны бусад хүмүүс оролцлоо.

сансар судлалын талаар нийтлэгдсэн ном, товхимол зэрэг олон сонирхолтой эд өлгийн дурсгалууд багтсан байна.

Тэрээр арга хэмжээний үеэр хэлсэн үгэндээ, “Архив гэдэг улс орон хийгээд хувь хүнд чухал ач холбогдолтой юм. Хүн



болон эд өлгийн зүйлсийг Үндэсний төв архив хүлээн авлаа. Мөн архивын сан хөмрөгийг баяжуулсан эдгээр баримтаар бичил үзэсгэлэн дэлгэсэн юм. Уг үйл ажиллагааг Архивын ерөнхий газар, Үндэсний төв архив, Одон орон геофизикийн хүрээлэн хамтран зохион байгуулсан бөгөөд ёслолын арга хэмжээнд Монгол Улс, ЗХУ-ын баатар, сансрын

Монгол Улс, ЗХУ-ын баатар, сансрын нисэгч, хошууч генерал Ж.Гүррагчаагийн хувийн гаралтай баримтуудаас онцолбол, түүний намтар түүхэнд холбогдох баримтууд, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдээс гаргасан зарлиг, тогтоол, шийдвэрийн хуулбар, сонин сэтгүүлд өгсөн ярилцлага, өөрийн бичиж хэвлүүлсэн ном, өөрийнх нь амьдрал үйлс,

гэдэг амьтан “Томилолт”-оор ирээд тодорхой цаг хугацааны дараа буцдаг бол түүний ажил үйлс, амьдралтай холбогдох баримт, материал сэлт мөнх аж. Надтай холбоотой бүхий л баримт сэлт, эд өлгийн зүйлийг тордож, ийнхүү дүрэм, журмынх нь дагуу хүлээж авсан Архивын ерөнхий газрын хамт олонд талархлаа илэрхийлье” хэмээв.

## “ҮЕ ДАМЖСАН ХУРАНДАА ГЭР БҮЛ” УУЛЗАЛТ БОЛЛО



Ардын хувьсгал болон Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооноос хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Ахмадаа сонсьё” аяныг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ аяны хүрээнд “Үе дамжсан хурандаа гэр бүл” уулзалтыг зохион байгуулж, тус хорооны оршин суугчдаас бэлтгэл, чөлөөнд гарсан ахлах офицеруудыг урин оролцуулж тэдний анх цэрэгт хэрхэн ирсэн тухайгаас эхлээд алба хаах үеийн сонин, содон үйл явдууд болон хамгийн нандин түүх, дурсамжуудын талаар хуучлан ярилцсан юм. Уулзалтад гурван

үе дамжсан хурандаа гэр бүлийн төлөөлөл болох хурандаа С.Иншдорж агсны хүү, чөлөөнд байгаа хурандаа И.Пүрэвцогт, түүний хүү цагдаагийн хурандаа П.Энхбаяр нар хүрэлцэн ирсэн нь онцлог байсан бөгөөд цэргийн хүний гэр бүл хэр ёс журамтай, шударга, зарчимч байдаг талаар халуун дотно яриаг бий болгосон юм.

Энэ үеэр тус хорооны “Ахмадын зөвлөл”-ийн даргаар 2010-2012 онд ажиллаж байсан чөлөөнд байгаа хурандаа Н.Доржханд хэлсэн үгэндээ, “Баянзүрх дүүргийн 16 дугаар хороог “Цэргийн хороо” гэж бид нэрлэдэг. Учир нь өмнөх нийгмийн үед цэргийн хотхон байх үеэсээ олон зуун офицер, ахлагч амьдарч, ажил хөдөлмөрөө

эрхлэн, үр хүүхдээ өлгийдөн авч, өсгөсөн байдаг. Тэр ч утгаараа энэ хорооны ахмадуудын ихэнх хувь нь бэлтгэл, чөлөөнд гарсан цэргийнхэн байдаг. Өнөөдөр зохион байгуулагдаж буй “Үе дамжсан хурандаа гэр бүл” уулзалтад манай гэр бүлийг урьсан явдалд маш их баяртай байна” гэлээ.

Уулзалтын төгсгөлд тус хорооны Засаг дарга Б.Булганхүү “Бид бүхний санаачилсан энэхүү уулзалтад хүрэлцэн ирсэн та бүхэнд маш их баярлалаа. Би өөрөө цэргийн хүний гэр бүлд өссөн хүн. Өвөөгөөс минь эхлээд аав, ах гээд бүгд цэргийн хүмүүс байдаг. Миний төрсөн дүү, хүү хоёр маань хүртэл төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын офицерууд. Тиймээс миний бие цэргийн хүний гэр бүлийн онцлогийг маш сайн мэдэрч өссөн хүмүүсийн нэг. Манай улсад үе дамжсан хурандаа нар цөөнгүй байдаг. Харин гурван үе дамжсан хурандаа гэр бүл тун ховор гэж бодож байна. Дээрээс нь нэг гэр бүлээс найман хурандаа төрөн гарна гэдэг мөн л ховор тохиолдол юм. Тиймээс та бүгдээр бахархахгүй байхын аргагүй” гээд уулзалтад ирсэн зочдод эрүүл энхийг хүсэж цаашдын ажил, амьдралд нь өндөр амжилтыг хүсэн өрөөлөө.

## ҮБХИС-ИЙН ОЮУТАН ГУРВАН ХҮНИЙ АЛТАН АМЬ АВАРЛАА

ҮБХИС

Өнгөрсөн 6 дугаар сарын 28-ны өдөр Дорнод аймгийн төв Чойбалсан хотод Хэрлэн голд живж байсан гурван хүний амийг нэгэн залуу аварчээ. Тэр аварч нь ҮБХИС-ийн АБДС-ийн эдийн засаг, менежментийн тэнхмийн оюутан Э.Баянхүү байсан аж. Тухайн өдөр түүнийг найзуудтайгаа салхилж явахад “Туслаарай туслаарай, хүн алга болчихлоо” гэж хашхирах сонсогджээ. Тэрээр голд хүн живчихсэн юм байна, хурдан аврах ёстой гэдгийг ойлгож шууд гол руу үсрэн орсон бөгөөд голд живж байсан хоёр охины төдийгүй тэднийг аврахаар араас нь орсон залуугийн амийг ч аварсан байна. Тухайн үед Хэрлэн голын үерийн түвшин 13 сантиметрээр даван үерлэж байсан аж. Живж байсан охидын тухайд, гар гараасаа атгалцаад хамтдаа гол гатлах гэж байгаад хөл алджээ. Охид аврагдсаны дараа эрэг дээр ухаан орсон байна. Мөн тухайн үед тэдний хажууд нэгэн эмч амарч яваад таарсан учир охидод хиймэл амьсгаа хийж, амийг нь аварчээ. Оюутан Э.Баянхүүгийн хувьд, хоёр жилийн өмнө найзгаа аварч байсан бол 20 гаруй хоногийн



өмнө нэгэн найзынхаа ахыг бас уснаас авран гаргаж байжээ.

Тэрээр сагс болон гар бөмбөг, ширээний теннис, библиардаар хичээллэдэг спортод элэгтэй нэгэн аж. Мөн тэрээр ирэх хичээлийн жилд Цэргийн нэгдсэн дээд сургуулийн Ерөнхий цэргийн ангид суралцах зорилготой бөгөөд ирээдүйд цэргийн

чадварлаг дарга болох мөрөөдөлтэй гэнэ. Хүний алтан амь насыг өөрийн амиа үл хайрлан эр зоригтойгоор аварсан бахархалтай эрлэхэг оюутан чамд их сургуулийн удирдлага, хамт олон, багш, сонсогч, оюутан, сурагчдаас нь сурлагын их амжилтыг хүсэж, чармайн хичээж мөрөөдөл хүсэлдээ заавал хүрээрэй гэж өрөөе.

## “ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ҮНДЭС” УРИА ДЭВШҮҮЛЭВ

Зэвсэгт хүчний 186 дугаар анги



Ангийн бие бүрэлдэхүүн коронавируст халдварын цар тахал нэмэгдэж, иргэдийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулж байгаа энэ үед Орхон аймгийн Засаг даргын гаргасан “Заавал мөрдөх 5 зарчим”-ыг дагаж хэрэгжүүлэн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, айл өрх, албан байгууллага бүрт санамжуудыг

тараан байрлуулж, уриалгыг дэвшүүлэн ажиллалаа. Мөн “Ахлагчийн эрүүл мэнд, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх жил”, офицер ахлагчийн түвшин тогтоох үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд “Идэвхтэй хөдөлгөөн эрүүл амьдралын үндэс” уриа дэвшүүлэн ангийн биеийн тамир, спортын офицер,

ахлах ахлагч Э.Бархүүгийн санаачилгаар 150 орчим унадаг дугуйны зогсоолыг ангийн байрлалд байгууллаа. Цаашдаа Орхон аймаг дахь Биеийн тамир спортын газартай хамтран унадаг дугуйн аян, 15, 30 километрийн марш зохион байгуулахаар төлөвлөж байна.

Хошууч Я.ЗАЯАНДАРЬ



# Уриалга

Монгол цэргийн эр зориг, тэсвэр хатуужлыг өөрөөрөө үлгэрлэн яваа бидний мөрдэс, зорилго нэгт Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ахлах ахлагч Э.Даважамц Ховд аймгаас Дорнод аймаг хүртэлх 2100 гаруй км замыг туулахаар гүйж явна.

Дайны хүнд жилүүдэд цэргийн алба хаагчид Ховд хотоос Чойбалсан хот хүртэлх зэвсэг техниктэйгээ туулж байсан тухуулг энэ цагт эх орны зүү явганаар туулж, Монгол Улсад тооцогүй дэхлээд онцгой амжилт тогтоохоор зориг шулуудан Монгол Улсын төрийн далбаатайгаа хамт эх орныхоо говь, хангалт хангалон гулд туулж явна.

Эр зоригт эрхэм журмын нохортоо шаардлагатай санхүүжилтийг нь бүрдүүлэх хүрээнд “Сэтгэлийн дэмжлэг” хандлаг оргохлаг, Зэвсэгт хүчний Жанжин штабын Сүргэлтийн боолог, зохицуулалтын хэлтсийн Биеийн тамир, спортын тасгаас Зэвсэгт хүчний Төрийн цэргийн командал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудын алба хаагчдааа уриалж байна.

“Урсгасан хөлс бүхэн нь эх орныхоо төлөө” уриатай журмын нохор дэмжлэг, урам хайрлагыгаа.

Хандивын данс: **ХААН БАНК**  
5920562264 С.Энхтайван